

**ХӨХ СУДАР РОМАНЫ ТОВЧИТ ТОЛТ ХИЙГЭЭД
УРАН ДҮРИЙН ХАРЬЦААНЫ АСУУДАЛД**

Б. Хишигсүх^{*}, В. Янжиндулам^{*}

Түлхүүр үгс: зохиолчийн дуу хоолой, ертөнцийг үзэх үзэл, арга билиг, таван махбодын онол, номын ёс, бичгийн сургаал

Аливаа зохиолын уран дүр, утга, үзэл санааны нийгмийн ач холбогдол нь тухайн зохиолчийн туйлын хүслэн, ертөнцийг үзэх үзэл, хувь хүний дотоод зөрчил, амьдрал ба тухайн нийгэм-цаг үедээ хандах хандлагаар илэрч, зохиолчийн оюун санааны амьдралын бодит тусгал нь болж байдаг. “Хөх судар” түүхэн-уран сайхны романы дүрийн тогтолцоо, үзэл санаанд Монголын суу билигт зохиолч Инжаннашийн ертөнцийг үзэх хувь үзэл, гүн ухааны итгэл үнэмшил, онол баримтлал нь хэрхэн нөлөөлсөн асуудлыг тодруулахыг хичээлээ.

Их зохиолч эл романыхаа уран дүрүүдийг хэрхэн хэлбэршүүлсэн, зохиолын агуулгыг яахин биежүүлж, ямар санаанд төвлөрүүлсэн асуудлыг түүний оюун санааны амьдрал, ертөнцийг үзэх үзлээс нь тодруулж харуулах нь зүйтэй. В.Инжаннаши “урлаг-утга зохиолын онол, гүн ухааны бие даасан, системтэй бүтээл бичээгүй ч зарим зохиол туурвил дотор шууд буюу дамаар дурдсан зүйлс их юм”¹ гэж үзжээ. Үнэндээ Инжаннашийн Товчит толт нь хэдийгээр бидэнд гүйцэд уламжлагдан ирээгүй ч түүний урлаг уран зохиол, ертөнцийг үзэх үзлийг нь бүрэн агуулсан гол цогц бүтээл юм. Эндээс бид зохиолчийн урлаг, уран зохиолын талаар ямархан үзэл баримтлалтай, гүн ухаан, гоо зүйн сэтгэлгээнийх нь уг үндэс, эш онолыг бага боловч тодруулах боломжтой юм. Тухайлбал, “Хөх судар” романы оршил 8 анги “Товчит толт” болон эхний 30 бүлэгт хийсэн зохиогчийн цохолбороос В.Инжаннашийн урлаг гоо сайхны үзэл, үнэлэмж, үндэсний ардчилсан үзэл санаа, эх хэл угсаа гарлаа дээдлэх, монгол үндэстний язгуур соёлыг сэргээн мандуулах ардчилсан үзэл, гүн ухааны баримтлал зэргийг тодорхойлох боломжтой гэж үзэж байна.

Их зохиолч В.Инжаннашийн ертөнцийг үзэх үзэл, гүн ухааны онол сэтгэлгээний үндсийг эрдэмтэн судлаач Г.Буянбат “В.Инжаннашийн үзэл санааны тухай”² Десрейжав “Их зохиолч Инжаннашийн ертөнцийн үзэлтийн тухай”³ судлаач Аймэй

^{*} МУИС, Шинжлэх ухааны сургууль, Утга зохиолын тэнхим

^{*} МУИС, Ховд Их Сургууль

¹ Буянбат.Г(1982), Инжаннашийн утга урлагийн үзэл санаа. АЛТАН ТҮЛХҮҮР.

² Инжаннашийн тухай судалгааны өгүүлэл (1982)8 ӨМАХХ.

³ Десрейжав (1993), Их зохиолч Инжаннаши, Бээжин, 1-18-р тал.

“Инжаннашийн арга билгийн үзэлтийн үүсэл, ирлийн тухай”⁴ судлаач Хас “Инжаннашийн зохиол бүтээл дэх уг цогцын онол ба аргазүйн тухай”⁵, судлаач эрдэмтэн Буян “Инжаннашийн шүтээнгүй онолын тухай”⁶ эрдэмтэн Оюунгуа “Инжаннаши хийгээд бичгийн сургаал”⁷ Эрдэнэхад “Буйг саатуулах амьдралын үзэлтийн тухай”⁸ Ихсүрэн Инжаннаши хийгээд буддын сургаал” зэрэг судалгааны өгүүлэл бичжээ.

Эрдэмтэн судлаач Намжилцэвээн, Г.Жамсранжав, Ч.Жүгдэр, Ж.Төмөрбаатар, Л.Хүрэлбаатар нар өөрийн судалгаандаа В.Инжаннашийн ертөнцийг үзэх үзэл, гоозүйн үзэл, нийгмийн ухамсар, үзэл баримтлалын талаар судалгаандаа дурдсан байна.

Академич Ч.Жүгдэр Инжаннашийг хоосон чанарын онол, төв үзлийг баримталж байсан гээд “Инжаннашийн нийгэм улс төр болон гүн ухааны сэтгэлгээ нь түүний шашныг шүүмжилсэн шашингүй үзэлтэйгээ нягт холбоотой байжээ. Олон зуун жил хойт насны төлөө залбирснаас энэ насандаа хийж бүтээх, сэтгэхийг уриалж шашны мухардлаас гарахыг уриалсан соён гэгээрүүлэгч байв”⁹ гэж үнэлж дүгнэсэн

“Монголын философийн түүх” номд эрдэмтэн Д.Дагвадорж Инжаннашийн гүн ухааны сэтгэлгээ, нийгэм улс төрийн байр суурь, шашны үзэл, ёс зүй, гоо сайхны үзэл сургаалыг дэлгэрэнгүй тайлбарласан байна¹⁰. Инжаннаши нийгмийн олон талт асуудалд гүн шүүмжлэлтэй хандаж, шинэтгэх үйл ажиллагааг тууштай дэвшүүлэн тавьж тухайн цаг үедээ дэвшилтэт ардчилсан соён гэгээрүүлэгч байсныг тодруулжээ.

Судлаач эрдэмтэн Д.Болормаа “Хөх судар”-ын товчит толт нь цохолбор болох тухайд авч үзээд “нийгэм түүх, утга зохиол, улс үндэстэн эрдэм мэдлэгийн тухай бага биш зүйлийг судлан утга зохиолын нийгмийн үүрэг, зохион бичих, үндэсний онцлогийн талаар чухал санаа дэвшүүлэн гаргасан”¹¹ гэж тэмдэглэжээ.

Судлаач Десрейжав өгүүлэлдээ түүний ертөнцийг үзэх үзлийн зөрчилтэй талыг тодруулан авч үзээд Орчлон ертөнцийг арга билгээс бүтсэн гэснийг “Инжаннашийн нийгмийн үзэлтэнд **бодосч** реалист\ үзлийн элемент бас байх юм”¹² гээд богд эзэн тэнгэрээс заяаж, тэнгэрийн хүчээр дайснаа дарж, өлсөж ундаасан бэрхдэхэд тэнгэр эзнээс аврал эрсэн үйл явдалд сэтгэлч үзлийн илрэл бий хүний үзэл санаа, эрдэм мэдлэг ёс моралийг тэнгэрээс соёрхохоос биш үйлдлэгээс болохгүй гэж **сэтгэлч** үзлээр\ идеалист\ тайлбарласан байна.

Уран зохиолын онолд зохиолчийн дуу хоолой гэх ойлголт буй. Энэ нь “*Зохиолч өөрөө зохиолын хэрэг явдал руу орж, зохиолын өрнөлтийг далдаас зохицуулах, зохион байгуулагчийн байранд ахуйдаа өөрийн үзэл бодол, байр сууриа баатруудын ярианд санаатай ба санамсаргүйгээр шингээх үзэгдэл бий. Ийм маягийн зохиолчид хамаарахуйц хөндлөнгийн хүүрнэл хэсгүүдэд шингэсэн зохиолчийнх хэмээн танигдахуйц байдлыг зохиолчийн дуу хоолойн маяг /author’s panaramic survey/ гэнэ*”¹³ гэнэ.

⁴ ӨВӨР МОНГОЛЫН НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН (2002), Хөх хот, №1, 20-26-р тал.

⁵ АЛТАН ТҮЛХҮҮР (1996), Хөх хот, №1, 28-34-р тал.

⁶ ӨМБИС, ЭШС (2001) №2.

⁷ ӨМБДС-ийн ЭШС (1997 хавар) (гүн ухаан нийгмийн шинжлэх ухааны монгол хэвлэл) №56

⁸ ӨМИС 4-р удаагийн МСОУЭШЯ хурлын эмхтгэл

⁹ Жүгдэр Ч. (1972), XIX-XX зууны зааг дээрх монголын нийгэм улс төр философи сэтгэлгээний хөгжил. УБ., 81 дэх тал

¹⁰ Монголын философийн түүх IV (2001), Улаанбаатар, 424-448-р тал.

¹¹ Болормаа Д (2012), Монголын уран зохиол дахь цохолборлон бинтлэх арга, Улаанбаатар.

¹² Десрейжав (1993), Их зохиолч Инжаннаши, Үндэсний хэвлэлийн хороо, 6-р тал.

¹³ Галбаатар Д. (2012), Уран зохиол онол, түүх, шүүмжлэл, нэвтэрхий толь, Улаанбаатар, 174-р тал.

Монголчуудын түүхэн туужсын зохиолын цохолборлон бинтлэх арга зүй нь нэг талаар зохиогчийн тайлбар шүүмжийн шинжтэй ба зохиогчоос тухайн үйл явдал, дүрийн зан төрхийн илрэл, нөхцөл байдалд өгсөн үнэлэлт дүгнэлт гэж болно.

В.Инжаннаши “Хөх судар”-ынхаа “Товчит толт”-ын долдугаар ангид “Энэ орчлон хэмээгч тэнгэр газар, наран сарнаас дараалан түмэн бодист хүртэл цөмөөр арга билгийн хоёр амьсгалаас үүсч таван махбодийн зүй шалтгаан лугаа хослолдон барилдаж бүтээгээд дэлхий дүүрэн бодис юм дэлгэрсэн”¹⁴ хэмээн онцгойлон тодорхойлжээ. Байгаль, ертөнц ба хүн төрөлхтнийг нийтэд нь багтаасан энэ орчлонд тэнгэр газар, наран саран, ургамал амьтан, түмэн бодис, цугаар арга билгийн жам ёсноор дэлхийн бөмбөрцөг дээр цогц дүүрэн бодис юмс дэлгэрчээ. Энэ бол байгаль ертөнц хүн төрөлхтний орчиж аж төрөх, оршин тогтнох хийгээд хөгжин бадрахын суурь хэмээн ойлгож асныг илтгэх юм. Арга, билгийн хос хоёр амьсгал үгүйсэн бол байгаль-нийгэм, хүн төрөлхтний ахуй амьдрал оршиж чадахгүйн шалтгаан нь орчлон өөрөө бүхэлдээ арга билгээс бүтсэнийх юм. Эрдэмтэн Хас “Инжаннаши...арга билгийн 2 амьсгалаас “дэлхий дүүрэн бодис юм дэлгэрсэн” тул амьсгал бол ертөнцийн уг эх мөн” гээд Инжаннаши нь “арга, билгийн хоёр амьсгалын сургаал” ба “таван махбодын зүй шалтгааны аргазүйг уялдуулан **борогжуун бодисч** /гэнэн реалист В.Я/ ба **зөнгөр хувьсангуй аргыг** уялдуулсан гүн ухааны онолын тогтолцоог үүдэн бүтээжээ”¹⁵ гэжээ.

Энэ эшлэлээс үзэхүл тэнгэр-газар хоёрын шүтэн барилдлагыг монголчууд хийвэрлэн томьёолсон арга билгийн сэтгэлгээ ба эртний хятадын философийн инь /ян /-ын онолыг цохон тэмдэглэж, түүний үйл ба үрийн тухайд тодруулж өгүүлсэн нь зохиолчийн ертөнцийг үзэх үзлийнх нь нэг тулгуур үзэл мөн гэлтэй. Эртний хятадын философийн эл инь, ян гэх томьёолол нь эсрэг хүчнүүд ба тэдгээрийн харилцан үйлчлэл бол ертөнцийн оршин буй бүхний үндэс, мөн буй бүхэн хувьсаж, өөрчлөгдөхийн үндсэн шалтгаан болно, инь бол ямар нэг газар, эх хүн, харанхуй, хүйтэн, зөөлөн, идэвхгүй эхлэлийг, харин ян бол тэнгэр, эцэг хүн, гэрэл, халуун, хатуу, идэвхтэй эхлэлийг илэрхийлдэг аж. Энэхүү эсрэг тэсрэг хоёр хүч, харилцан биесийг үгүйсгэхийн дээр нөхцөлдүүлж, эцсийн дүндээ нэгдэл, зохицолд орших ба тэрхүү нэгдмэл байдлыг “ци” хэмээн томьёолжээ. Тэрхүү харилцан зохицол, нэгдэл нийтлэгийн мөн чанарыг В.Инжаннаш “Сайн муу хэмээгч арга билгийн хоёр амьсгал мэт толгой сүүл залгалдсан”¹⁶ гэсэн бөгөөд энэ тухайд судлаач Десрейжав “нэгэн зүйлийн хэрэг бодисоос өөр зүйлийн хэрэг бодис буй болох **хувьсангуй аргыг**” /диалектик/ өгүүлсэн гэж үзсэн билээ.

Үүнээс бид зохиолчийн арга билгийн онол үзэл баримтлал нь Хөх судар романы гол дүрийн бүтэц байгууламжид тусгалаа олсон гэж үзэж байна. Хөх судар романд 300 гаруй дүр дүр дүрслэгддэгээс зохиолын гол ноён нуруу болсон гол дүрүүдийн харьцааг ажиглавал сайн-муу, сайхан-муухай, үнэнч-урвагч, харгис-өршөөнгүй зэрэг дүрийн зан төрхөөр нь эсрэгцүүлэн, өөрөөр хэлбэл, Чингис-Жамуха, Мухулай-Хэ ван, Ялгуу-хүлэг Боорчи, Алтаншагай-Солонгуа, Идэрдов-Полгудайн нарын дүрийн харилцааг эсрэгцүүлэн арга билгийн ёсоор шүтэлцүүлэн барилдуулж дүрсэлсэн байна. Тухайлбал, зохиолч Чингисийн өршөөл дүүрэн, туйлбарт зан төрхийг Жамухын аминч хувиа хичээсэн туйлбаргүй зан төрхөд сөргүүлэн, Мухулайн чигч шударга зан төрхийг Хэ

¹⁴⁾ Инжаннаш В. (1957), Хөх судар, Хөх хот, 72-р тал.

¹⁵⁾ АЛТАН ТҮЛХҮҮР, Хөх хот, 1996, №1. 28-р тал.

¹⁶⁾ Инжаннаш В. (1957), Хөх судар, Хөх хот, ӨМАХХ., 63-р тал.

вангийн урвамтгай, холбиромтгой зан төрхтэй тэгш хэмтэй эсрэгцүүлэн зохион байгуулсан дүрийн ерөнхий бүтцийг харж болох юм.

Эдгээр дүрүүд нь харилцан эсрэг тэсрэг мэтээр харагдах ч эв эе, үндэс угсаа, мандал бадралын төлөө гэсэн зохиолын гол үзэл санааг ертөнцийн үүсгэл оршихуйн мөн чанар, үйлийн үр хөврөлөөс биежих “хоёр амьсгал мэт толгой-сүүл залгалдсан”-ы шалтгаанаас нөхвөрлөн гаргасан зохиолын дүрүүдийн бүтцээс тодорхой харагдана.

Ер нь “Зохиолчийн амьдралаас олсон бүх мэдлэг, туршилагадаа тулгуурлан өөрийн итгэл үнэмшил болгосон хувийн үзэл бодол мэдлэгийн цогцолбор”¹⁷ нь зохиолчийн ертөнцийг үзэх үзэл болохынхоо хувьд Инжаннашийн арга билгийг шүтэх үзэл, ардчилсан үзэл санаа нь түүний зохиолын баатрын зан төрхөд гүн шингэжээ. “Уран бүтээлд барих зарчим, урлах арга, үзэл онол, дүрслэх хэв маяг, гүн ухаан, үзэл санааны төлөвшил ч хамааралтай ба энэ нь амьдралын олон талт үзэгдэл явдлын зүй тогтол харилцан хамаарлын учирзүйг тайлахад нь тусалдаг”¹⁸ үнэхээр зохиолч, бүтээлээ туурвиж байхдаа өөрийн ертөнцийг үзэх үзлээ чөлөөтэй тавьж, түүндээ захирагдах тул урлан бүтээх бүхий л үйл явцад уг үзэл баримтлал нь үндэс суурь болж тухайн зохиолын агуулга, утга санаа нь үүнд түшиглэн биеждэг аж. Тэгэхээр зохиолч Инжаннашийн үндэсний үзэл санаа нь түүний “Хөх судар” романы өршөөл нигүүлсэл, бат журам, элбэрэл тахимдуу хосолсон нэн гайхамшигт сайхан дүрүүдээр нь биежин илэрсэн юм.

В.Инжаннаши “Товчит толт”-ын II ангид “Энэ судар хэмээгч Их Юан улсын **төв судар** бөгөөд энэ Юан улс эл хүний чихэнд сонстсон газар бүхнийг эс эзэлсэн, эс хүрсэн бээр үгүй”¹⁹ хэмээсэн нь хэдий тэр, эл судрыг зохиохдоо арван анги судар бичгийг ашиглан залган цөлбөж, түүхэн он цагийг эрэлхийлэн сурвалжилж, түүхэн үнэнийг гол тулгуур төв болгож бичсэн ч үнэндээ тэр зохиолын баатруудын хөрөг дүрийг уран зураглан, зан төрхийг нь гайхам ялгаруулж түүхэн роман биччихсэн билээ. Зохиолч энэ бол сул шастир, тууж биш “Төвийн гол судар” хэмээн баталсан ч түүний бүтээл үнэндээ урлаг, уран сайхны талаасаа гайхамшигтай боловсорсон уран зохиол юм. Ийн нэрлэсэн нь өөрийн үндэстэн монгол тоотноо бахархах үүх түүхтэй, давхар давхар дарлал мөлжлөгт буй Чин гүрний үеийн отог чулуунд толгой бөхийн, ван бэйл бэйсийн зэрэг цолын төлөө хөрөнгө цугтан, өвөр хоорондоо тэмцэлдэгч монгол ноёдыг сэрээсэй санаасай гэсэн сэтгэлийн дуудлагаар бичсэн бөгөөд тэрээр түүхэн хүн Чингис хааны бодит түүхэн үйл явдалд тулгуурлан өөрийн туйлын хүслэнгийн эрдэм ухаан, өршөөл нигүүлсэл төгс хосолсон Чингис хааныг дүрийг бүтээжээ. Тиймээс ч эрдэмтэн судлаачид “Хөх судар” романыг “түүхэн үлгэр”²⁰, “анхны монгол роман”²¹ “ууган түүхэн роман”²² хэмээн үнэлж дүгнэсэн нь бий. Харин монголын томоохон эрдэмтэд “Хөх судар”-ыг түүхэн сурвалжийн цувралд оруулсан нь Инжаннашийн товчит толтдоо манж, хятад сударч бичээч нарын атхаг санаандаа монголын ялан мандсан түүхийг

¹⁷) Галбаатар Д. (2012), Уран зохиол онол, түүх, шүүмжлэл, нэвтэрхий толь, Улаанбаатар, 174-р тал.

¹⁸) Галбаатар Д. (2012), Уран зохиол онол, түүх, шүүмжлэл, нэвтэрхий толь, Улаанбаатар, 174-р тал.

¹⁹) В.Инжаннаш В. (1957), Хөх судар, Хөх хот.

²⁰) Буянбат Г (1988), Инжаннаши ба түүний Хөх сударын тухай, Хөх хот.

²¹) Михайлов. Г., Яцковская.К. (1969), Монгольская литература. Москва, стр. 97.

Билигсайхан. Ч, Түүх, эрхис, товчис. Улаанбаатар, 12-р тал.

МУЗД, боть. 66, 116-р тал.

²²) Эү Юүвэй (2002), Инжаннаши ба түүний зохиол бүтээлийн тухай судлал, Үндэстний хэвлэлийн хороо, 76-р тал.

орхин, хураан бичсэнд хорссоноос хариу нэхэн мандуулан бадруулан бичсэн их зориг цөсөд нь итгэснийх юм болов уу.

Будда “Ланкарт ажирсан нь” алдарт номлолдоо хүмүүний оюуны сурц чармайлга, оюун ухааны төвшин, гэгээрлийн төлөөх явдал мөртэй нь холбож өөрийн номлол сургаалаа хоёр түвшинд айлдсанаа дурдсан бий. “Бурхадын номын ёс нь хоёр зүйл болой.

Энэ нь шашны ёс хийгээд тогтсон тааллыг тус тусад нь ялгахын ёсон юм. Түүнд шашныг өгүүлэхийн ёс аль хэмээвээс энэ нь элдэв номын судрын номлол хийгээд амьтадын сэтгэл болон бишрэлийг ямар мэтчилэн үзүүлэх болой. Түүнд тогтсон тааллын ёсон аль хэмээвээс энэ нь алинаар егүзэрүүд өөрийн сэтгэлийн үзэгдлийн тийн атгагийг няцуулан үйлдэх болой. . . Түүнд ийн хэмээх бөгөөд: Миний ёс нь хоёр зүйл бөгөөд тогтсон таалал хийгээд шашин болой. Нялхсуудад өгүүлэхийг номлох /шашин/, егүзэрийнхийг тогтсон таалал/гүн ухаан/ гэх бөлгөө”²³. Мөн “суурь болсон мэдэгдэхүүнийг сайтар оноон тайлж, чанагш хэрхэн үйл явдлаа хянан боловсруулах арга зам болсон үнэний мөрөөр замнан хүрсэн үр дүн, гэгээрлээр нь гурван бодгалийн төвшинд”²⁴ ангилан үздэг. Чухамхүү сургаал номлол /шашин/, тогтсон таалал /гүн ухаан/ гэх дээрх хоёр ойлголттой дүйлгэж болох санааг их зохиолч Инжаннаши ийн өгүүлжээ.

Энэ ном бичиг хоёр сургаал, угаас нэгэн адил цөм сайн сэтгэлийн үндсэн бөгөөтөл номд хоосныг мохол болгож, орчлонгийн мэргэдийг хоосны хойноос хөөлгөчихүй. Бичигт буйг баримталж ертөнцийн амьтныг буйн хойноос нэхүүлчихүй. Ийнхүү авш нь зөрчсөнөөр хоёр хоёр сургаалын мөчид ард харилцан үл тоомжлох атгаг санааны ном бичиг хоёул өвөрлөсөн бус уу... буй хоосон хэмээх үгс хэлэхэд хоёр өөр үгс боловч санаа нь нэгэн болой...Энэ буй хоосон хоёул толгой сүүл залгалдсан нэгэн гархи мэт үг буюу²⁵ хэмээсэн нь Инжаннашийн гүн ухааны үндсийг тодорхой илтгэсэн ба энэ үзэл нь буддын гүн ухааны төв үзлийн ёсны хоосон чанарын онолтой яв цав тохирч буйг төдий л гайхах хэрэггүй юм. Түүний ном ба төр ёсны үзэл санаа төлөвшихэд буддын сургаал номлол нөлөөлсөн нь магадтай юм. Тэр,сурвалжит сэхээтний өсч хүмүүжих орон зай, уламжлал болсон олон хэл, үзэл онол, элдэв ном шастирыг багаас уншиж өссөн намтар түүхээс тодорхой юм.

В.Инжаннаши багаас хятад хэл, соёлын боловсрол эзэмшиж зурах бичих, зохиох үйлд дуртай болсон учир Хятад үндэстний Күнз Мэнз, Зэнз нарын эрдэмт хүмүүсийн ном бичигтэй танилцсан тул “Их суртахуй бичиг”, “Дүн Жияан Ганму” бичиг зохиол дахь үзэл санаа түүнд их нөлөөлжээ. Хөх сударын товчит толтын 8-р ангийг хятадын

²³) Lankavatarasutra, Ланкадажирсаннь, /phags pa langkargshesgsa'itheg pa chenpo'imdo/ 197b-198a,

²⁴) Гурван бодгаль:1. Шравак (мо: сонссоноо дуурсгагч, тө: ཤྭ་ཐོག་ལོ་མོ་ ca: śrāvaka,) гурван хөлгөний нэг шравакийн хөлгөнд орсон бодгаль. Их хөлгөний аймаг савыг өөрөө анхааран үл авсан бөгөөд бурхан тэргүүтнээс ном сонссоны учир сонсогч буюу шравак хэмээсэн буй. Сонссоноо бусдад дуурсгах учраас сонссоноо дуурсгагч ч хэмээмүй [БШСТТ. I-1999: 501]. 2. Брадигабуда (мо: өөрөө гэгээрсэн, тө: བླ་མོ་ལོ་མོ་ ca: pratyekabuddha) Брадигабуда нь өөрөө ганцаар оршихуйд баясах бөгөөд эцсийн цагт бусдын увдист үл дулдуйдан өөрийн бодийг илт болгох бөгөөд нисваанисаас ялж үйлдэх тул тийн нэрлэмүй. Брадигабудад хирсийн эвэр мэт бөгөөд чухал явагчих, өчүүхэн хоёр бөгөөд гурав болой [БШСТТ.I-1999: 150]. 3. Бодьсатва (мо: бодь баатар сэтгэлт, тө: བློ་སྦྱོར་མཁེལ་འཇམ་འགྲུབ་པོ་ ca: bodhisattvā) Их хөлгөний суралцах мөрийн бодгаль бөгөөд их бодийг олохын тул галавын өнө, газрын холыг үл ажран, тэргүүн ба үе гишүүний өглөг өгөхөд сэтгэл үл мятрах учир бодьсатва бодь баатар сэтгэлт хэмээжээ. [БШСТТ.I-1999: 146]

²⁵) В.Инжаннаш (1957), “Хөх судар”, Хөх хот, 52-р тал.

философийн ноён оргил гүн ухаантан Күнзийн намтар түүх, эш онолыг тайлбарлахад зориулсан байна.

Ёс суртахууны хувьд бол “Хөх судар”-ын Чингис хаан бол феодалын **өршөөл, журам, ёслол, мэргэн, батын** төрөлх зөн билгээс үүтэж, “аяндаа сургаалгүйгээр явж” чадсан гэгээн эзний дүр юм. Чингис дүү нартайгаа бат нягт явж чадсан, эх Өэлүнийг үлэмж их асран хүндэлсэн зэрэг нь “ёслол”-ыг гүйцэтгэж, Тэмүжин хэлсэндээ хэзээд хүрдэг нь “бат”-ыг үзүүлж, эрдэмтэн мэргэдийг хүндэтгэн хэрэглэдэг нь түүний мэргэнийг харуулсан ажээ.

Инжаннаши, Чингисийг “Үг явдал цөмөөр чин үнэн мөн чанараас үүсгэж төрсөн сэтгэл буй за. Сурах ба дуурайснаар үсний төдий өө үгүй болой. Суртал ёслол цэвэр ичгүүр үгүй газар хэмээх бөгөөд дөрвөн их, таван үүрдийг ярандаган сургаалгүйгээр явж чадсан үнэхээр эзний шинжтэй юм. Чингисийн дүрийн эрх чөлөө адил тэгшийн тухай Инжаннашийн дэвшилтэт үзэл нь Чингисийн чөлөөт ургийг дэмжин туслах, язгуур угсааг үл ялгадаг зан чанараар дамжин илэрсэн юм.

Хөх судар романы дүрийн зан төрхийг бүрдүүлэхдээ Инжаннаши өөрийн итгэл үнэмшилдээ тулгуурлан, үндэсний үзэлтэй, ёс суртахууны хувьд цэвэр ариун удирдагч баатрыг дүрсэлсэн явдал нь туйлын хүслэнгийн дүр (идеальный образ) болсон хийгээд Чингисийн хүлэг баатрууд, цэргийн жанжид нь ёс суртахууны хувьд өршөөл, журам, мэргэн батыг чандлан сахиж байгаа нь Инжаннашийн үзэл санаанд хятадын сонгодог философи Күнзийн сургаал нөлөөлснийх гэж үзэж болно.

Үүнээс дүгнэж үзвэл,

1. Их зохиолч Инжаннашийн ертөнцийг үзэх үзэлд нь арга билгээр шүтэн барилдаж хорвоогийн юмс оршин тогтнохоос гадна тэнгэр таалсан богд хүн ертөнцийг тохинуулах увидас чадалтайг илтгэн тэнгэр шүтлэг, номын ёс, бичгийн сургаалын зарим санаа зохиолын дүрийн үг хэл, үйл хөдлөл, сэтгэл санаа зан төрхөд илэрч байна. Иймээс их зохиолч Инжаннашийг олон ургальч үзэлтэй байж гэж үзэж болох юм.

2. В.Инжаннаши “Хөх судар”-ын гол дүрүүдийн бүтэц байгууламжийг арга билгийн хоёр амьсгалдаа шүтэлцүүлэн хэм тэгш зохиомжилсан байна.

3. Хөх судар романы дүрийн зан төрхийг бүрдүүлэхдээ Инжаннаши өөрийн итгэл үнэмшилдээ тулгуурлан үндэсний үзэлтэй, цэвэр ариун удирдагч баатрыг дүрсэлсэн явдал нь туйлын хүслэнгийн дүр(идеальный образ) болсон хийгээд Чингисийн хүлэг баатад, цэргийн жанжид нь ёс суртахууны хувьд өршөөл нигүүлсэл дүүрэн, үнэнч шударга мэргэн батыг чандлан сахиж байгаа нь зохиолчийн үзэл ухамсарт Күнзийн сургаал нөлөөлснийх гэж үзэж болно.

НОМ ЗҮЙ

1. АЛТАН ТҮЛХҮҮР (1996), Хөх хот, №3.
2. Билигсайхан Ч. (1984), Орчин цагийн монгол роман, Улаанбаатар.
3. Буянбат Г. (1982), Инжаннашийн утга урлагийн үзэл санаа, Алтан түлхүүр, 1982, №1.
4. Буянбат Г. (1988), Инжаннаши ба түүний Хөх сударын тухай, Хөх хот.

5. Галбаатар Д. (2012), “Уран зохиол онол, түүх, шүүмжлэл, нэвтэрхий толь”, Улаанбаатар.
6. Десрейжав (1993), Их зохиолч Инжаннаши.
7. Дэлгэр (1988), “Хөх судрын гол баатрын зан чанарын систем ба бүтэц” ӨМИС ЭШС №3.
8. Жүгдэр Ч. (1972), XIX-XX зууны зааг дээрх монголын нийгэм улс төр философи сэтгэлгээний хөгжил. Улаанбаатар.
9. Инжаннаш В. (1957), “Хөх судар”, Хөх хот, тэргүүн дэвтэр.
10. Инжаннаш В. (1957), “Хөх судар”, Хөх хот, дэд дэвтэр.
11. Михайлов. Г, Яцковская. К. (1969), Монгольская литература. Москва.
12. Монголын уран зохиолын дээжис, боть 66.
13. Монголын философийн түүх (2001), IV дэвтэр. Улаанбаатар.
14. ӨВӨР МОНГОЛЫН БАГШИЙН ИХ СУРГУУЛЬ (2001), ЭШС. №2.
15. ӨВӨР МОНГОЛЫН НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН, Хөх хот, 2002. №1.
16. ӨМБДС-ийн ЭШС (1997 хавар) (гүн ухаан нийгмийн шинжлэх ухааны монгол хэвлэл), №56.
17. ӨМИС 4-р удаагийн МСОУЭШЯ хурлын эмхтгэл.
18. Эү Юүвэй (2002), Инжаннаши ба түүний зохиол бүтээлийн тухай судлал. Үндэстний хэвлэлийн хороо.

SUMMARY

In this paper author mentions that, relation between authors world view and of characteristics of personages in Blue chronicle by well-known writer V.Injannashi. Writer’s philosophical attitude is kept in forward Tovchit tolt of historical novel Blue chronicle.

After 30 chapters Injannash wrote a kind of summary which includes author’s panoramic survey.While we indicating author’s world view, life attitude we can infer his artistic psychological form such as system of personages and significance-meaning.

The system and stucture of main characters tightly connected to Injannashi’s theory of method and wisdom, Some characters moral is kept Confusion’s school elements.